

“АЙТҮҮЛС” ХУВЬЦААТ КОМПАНИ



2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

## АГУУЛГА

Компанийн тухай .....	3
Хураангуй .....	3
Хөрөнгийн зах зээл .....	4
Уламжлалт дата төв .....	4
Модуляр дата төв .....	6
Блокчэйн дата төв .....	8
Хувьцаа эзэмшигчид .....	9
Төлөөлөн удирдах зөвлөл .....	10
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ .....	11
2017 оны үйл ажиллагаа .....	12
Аудитын дүгнэлт .....	16
Ногдол ашгийн талаарх мэдээлэл .....	18

## КОМПАНИЙН ТУХАЙ

### Хураангуй

Айтүүлс ХК нь компанийн дүрмэнд заагдсаны дагуу мэдээллийн технологи, програм хангамжийн үйлчилгээ болон гадаад худалдааны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд, үндсэн зорилгоо “хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, зах зээлд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж, худалдах /үйлчилгээ үзүүлэх/ замаар ашигтай ажиллаж, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг өсгөж, тэдний ашиг сонирхлыг ханган ажиллах” гэж тодорхойлсон.


Айтүүлс ХК нь 2011 онд байгуулагдан үйл ажиллагааг явуулж буй бөгөөд энэ хугацаан дахь онцлох үйл явдлуудаас дурьдвал:

*Хүснэгт 1. Онцлох үйл явдлууд*

Он	Онцлох үйл явдлууд
2011	<ul style="list-style-type: none"> <li>Компани байгуулагдав.</li> <li>Хөрөнгө оруулагчтай хамтарч хамтын ажиллагааг эхлүүлэв.</li> </ul>
2012	<ul style="list-style-type: none"> <li>Анхны дэд бүтцээ суурилуулав.</li> <li>Үйл ажиллагааг эхлэх бэлтгэлийг хангаж эхлэв.</li> </ul>
2013	<ul style="list-style-type: none"> <li>Өөрийн эзэмшлийн үл хөдлөх хөрөнгийг шилжүүлэн авч оффисыг шилжүүлэв.</li> <li>“Хост Монгол” ХХК-ийн хэрэглэгчдийг шилжүүлэн авлаа.</li> </ul>
2014	<ul style="list-style-type: none"> <li>Шинэ гүйцэтгэх захирал томилогдов.</li> <li>Үндсэн тоног төхөөрөмжийн хүчин чадлыг 2 дахин нэмэгдүүлэв.</li> <li>Монголын сайтын холбоо ТББ-ийн гишүүнээр элсэв.</li> </ul>
2015	<ul style="list-style-type: none"> <li>TEIR II түвшний өөрийн өмчлөлийн датацентрийг ашиглаж эхлэв.</li> <li>Бизнес ангилалын и-мэйл үйлчилгээг нэвтрүүлээ.</li> <li>Олон улсын APNIC байгууллагын гишүүн боллоо.</li> </ul>
2016	<ul style="list-style-type: none"> <li>Модуляр дата төвийн судалгаа, төслийн ажлыг боловсруулж эхлэв.</li> <li>БизМэйл үйлчилгээг зах зээлд нэвтрүүлээ.</li> <li>Компанийн логог оюуны өмчийн газраар баталгаажуулав.</li> </ul>
2017	<ul style="list-style-type: none"> <li>СЗХ, МХБ бүртгэгдэж ХК боллоо. Хувьцаагаа амжилттай арилжаалж эхлэв.</li> <li>Блокчэйн дата төв (Майнинг фарм)-ийн үйл ажиллагааг эхлүүлэв.</li> <li>IBM-тэй хамтран ажиллах гэрээг байгуулав.</li> <li>Дархан хот дахь модуляр дата төвийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэв.</li> <li>Австралийн RAC CORP компанитай хамтран ажиллахаар болов.</li> </ul>

### Хөрөнгийн зах зээл

Компанийн хувьцаа 2017 оны 11-р сарын 16-ны өдрөөс эхлэн МХБ-ийн хоёрдогч зах зээл дээр арилжаалагдаж эхэлсэн бөгөөд 2017 онд нийт 31 өдрийн арилжаагаар 6,2 сая үирхэг хувьцаа 1,2 тэрбум төгрөгийн хувьцаа арилжаалагдсан байна.



Зураг 1. Монголын хөрөнгийн бирж дээр арилжигдсан Айтүүлс ХК-ийн хувьцааны хани

Монголын хөрөнгийн бирж дээрх тус компанийн үнэлгээ 2017 оны эцсийн хаалтын дундаж ханшаар тооцсон үнэлгээгээр 6.7 тэрбумд хүрсэн байна.

### Уламжлалт дата төв

Айтүүлс ХК нь 2011 оноос уламжлалт дата төвийн үйл ажиллагааг эхлүүлсэн бөгөөд 2015 онд хоёрдугаар зэрэглэлийн өөрийн өмчлөлийн дата төвтэй болсон. Уламжлалт дата төвийн үйл ажиллагаа нь дараах бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдээс бүрдэнэ. Үүнд:



- Домэйн нэрийн бүртгэл  
Domain Name Registration
- Веб байршуулах үйлчилгээ  
Web Hosting Services
- Сервер байршуулах үйлчилгээ  
Co-location Services
- Интернет холболтын үйлчилгээ  
Internet Service Provider
- Борлуулалтын дараах үйлчилгээ  
Aftersales Services
- Физик серверийн түрээс  
Dedicated Server
- Виртуал серверийн түрээс  
Virtual Private Server
- Сэцэн бизнес багц  
Setsen Business Suite

Зураг 2. Уламжлалт дата төвийн үйлчилгээнүүд

Дээрх бүтээгдэхүүн үйлчилгээнүүд нь борлуулалтын орлогод нөлөөлөх хувь хэмжээг графикаар харуулбал:



Зураг 3. Уламжлалт дата төвийн бүтээгдэхүүний борлуулалтын орлогод эзлэх хувь, хэмжээ

Веб хост:

Дундын сервер нь вэб сайтуудыг байршуулахад зориулсан системийг тусгайлан бэлтгэсэн бөгөөд нэг серверийн тодорхой үзүүлэлт бүхий талбарыг хэрэглэгчдэд түрээслүүлэх үйлчилгээгээр хангадаг. Дундын сервер дээр олон тооны вэб сайтууд нэгэн зэрэг байршин ажиллах ба байгууллагын танилцуулга сайт болон хандалт багатай жижиг хэмжээний вэб сайт байршуулахад тохиромжтой.

Ресэллэр хост:

Хэрэглэгч вэб байршуулах үйлчилгээг цааш нь эцсийн хэрэглэгчдэд түрээслүүлэх, ашиглуулах боломжтой үйлчилгээ юм.

Виртуал сервер:

Бодит сервер дээр виртуалчлалын технологийг ашиглан, бие даасан хүчин чадалтай бүрэн хандалтын эрхтэй, бие биенээс нь үл хамааран ажиллахаар тохируулагдсан зохиомол байдлаар үүсгэсэн сервер юм. Ингэснээр физик сервер дээр хийж чадах бүх онцлогуудыг хямд зардалаар ашиглах боломжийг хэрэглэгчдэд олгодог юм

Физик сервер:

Серверийг физик түвшинд ашиглах үйлчилгээ

Сервер байршуулах:

Хэрэглэгчийн бодит сервер төхөөрөмжийг олон улсын стандартад нийцсэн байр талбай, орчин, сүлжээ, цахилгаан тэжээл, тэдгээрийн нөөц холболт, тасралтгүй ажиллагаагаар хангах үйлчилгээ юм.

Бусад:

Байршуулах үйлчилгээнд зайлшгүй шаардлагатай SSL, IP хаяг, архивлалт зэрэг бусад дагалдах үйлчилгээнүүд.

И-мэйл:


Цахим шуудангийн үйлчилгээ

Домэйн нэрийн бүртгэл:

Веб хаягийн үндсэн нэрийг бүртгэх, сунгах, шилжүүлэх үйлчилгээг хийдэг.

Одоогоор Монгол цахим хуудаснуудын 62.3% буюу дийлэнх хэсэг нь гадаад дахь дата төвүүдэд байршиж буй бөгөөд сүүлийн үед цахим хуудас эзэмшигчид зардлаа бууруулах болон цахим хуудсанд нэвтрэх хурдаа нэмэгдүүлэх зорилгоор дотоодын дата төвүүдэд цахим хуудсаа байршуулах хандлагатай байгаа нь уг зах зээлийн хувьд маш чухал үзүүлэлт юм. Тухайлбал, 2016 онд энэ үзүүлэлт 67.1% байсан бол 2017 онд ийнхүү 7.2%-аар буурсан байна.

### Цахим хуудас байршуулах үйлчилгээний зах зээл



### Модуляр дата төв

Шинээр байгуулах Модуляр дата төв нь олон улсын TIER III стандартыг шаардлагад нийцсэн, үйлчлүүлэгчийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангасан, цогц үйлчилгээ бүхий орчин үеийн дата төв байна. Манай улс геополитикийн ач холбогдол бүхий байршилтай, байгалийн гамшиг, улс төрийн үймээн самуун зэрэг давагдашгүй хүчин зүйлс тохиолдох эрсдэл харьцангуй бага, цахилгаан эрчим хүч, интернэт, харилцаа холбооны үйлчилгээний үнэ бусад улстай харьцуулахад хямдад тооцогддог тул Модуляр дата төвийг цаашид олон улсын түвшний дата төв болгон хөгжүүлнэ.

Дотоодын хэрэглэгчдийн хувьд газарзүйн нөөц дата төвийн зориулалтаар ашиглахад нэн тохиромжтой бөгөөд нэг хэрэглэгч нэг модуль буюу контейнер ашиглах боломжтой тул зөөвөрлөн хэрэглэх, хүчин чадлаа хэрэгцээндээ тохируулан өсгөх, багасгах бүрэн боломжтойгоос гадна мэдээллийн нууцыг баттай хадгалах, гал ус, гадны аюул эрсдлээс сэргийлэн хамгаалах давуу талтай юм. Манай улсын хөгжил нийслэл хотноо төвлөрсөнтэй холбоотой төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд бүгд Улаанбаатар хотод мэдээллээ төвлөрүүлэн хадгалж байна.

Хэрэв нийслэл хотод ямар нэгэн байгалийн гамшиг, давагдашгүй хүчин зүйл тохиолдвол бүх цахим мэдээлэл алдагдах, улмаар байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа доголдох, үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх эрсдэл маш өндөр байгаа тул мэдээллийг газарзүйн нөөц дата төвд давхар байршуулах шаардлага өнөөгийн цахимжиж буй нийгэмд зайлшгүй тулгарч байгаа билээ.

Модуляр дата төвийн паркийг нийслэл хотоос 220 км-ийн зайд, газар хөдлөлийн харьцангуй аюулгүй бүст байршдаг Дархан хотод байгуулснаар энэхүү шаардлагыг хангахад хувь нэмэр оруулах юм.

#### **Модуляр дата төвийн давуу талууд:**

- Контейнер дата төвүүдийг давхарлан тавих, орон зай байвал дата төвийн хүчин чадлыг хүссэн хэмжээгээрээ нэмэх боломжтой.
- Нэг байгууллага зөвхөн өөрийн хэрэгцээнд зориулан нэг модуль /контейнер эзэмших эсхүл түрээслэх боломжтой тул мэдээллийн физик тусгаарлалт, нууцлалыг бүрэн хангах боломжтой.
- Өөр системүүдтэй холбогдон ажиллах, тохируулах боломжтой тул хэрэглэгчийн үндсэн дата төвтэй интеграцлагдах боломжтой.
- Эдийн засагт хэмнэлттэй, өртөг зардлын хувьд үр ашигтай.
- Үл хөдлөх хөрөнгийн болон ашиглалтын зардлыг хэмнэдэг.
- Эрчим хүч болон бусад нөөцийг илүү үр өгөөжтэй ашигладаг, байгаль орчинд ээлтэй.
- Суурилуулалтын үеийн болон суурилуулсны дараах үйлчилгээ үзүүлэх үед гарах алдаа бага. Үйлдвэрлэгчээс баталгаа өгдөг. Нэг модульд нэг стандартын гэрчилгээ олгож баталгаажуулдаг тул модулийг бүрдүүлдэг олон эд ангийг тус бүрт нь сертификатжуулахаас зайлсхийх боломжтой.
- Дэлхийн хаана ч тээвэрлэн, зөөж хэрэглэх боломжтой. Амархан угсрагддаг.



*Зураг 4. Модуляр дата төвийн паркийн 3D байгуулалт. Гадна талаас*

Модуляр дата төвийн парк ашиглалтанд орсноор Айтүүлс ХК нь уламжлалт дата төвийн бүх үйлчилгээгээ Дархан хотоос үзүүлэх сонголттой болохоос гадна дараах бүтээгдэхүүн үйлчилгээнүүдийг зах зээлд шинээр нэвтрүүлэх боломжтой болох юм. Үүнд:

- Модуляр дата төв байршуулах
- Модуляр дата төв түрээслүүлэх
- Модуляр дата төв байршуулах
- Өгөгдөл, датаг эрсдлийн өөр бүсэд нөөцлөх замаар мэдээллийн аюулгүй байдлыг сайжруулах
- Монголын цорын ганц 3-р зэрэглэлийн сертификат бүхий дата төвд сервер, тоног төхөөрөмжүүд байршуулах

### Блокчэйн дата төв

Блокчэйн технологийн суурь бүтцэд зориулан цахим валют олборлох төхөөрөмжийг байршуулах фармын үйл ажиллагааг 2017 оны 7 сараас эхлэн бэлтгэж эхлүүлсэн.

Анхны фармыг 100м.кв байгууламжид тулгуурлан үйл ажиллагааг нь жигдрүүлсэн ба 300 м.кв бүхий хоёр дахь төвийг мөн үйл ажиллагааг нь жигдрүүлэн ажиллуулж байна. Фармын үйл ажиллагааг эрхэлснээр [www.cloudmining.mn](http://www.cloudmining.mn) системийн шаардлагатай хүчин чадлын хэмжээнд өөрийн удирдлага дор хэвийн ажиллуулах давуу талыг бий болгож байна.


Цаашид блокчэйн дата төвийн үйл ажиллагааг өргөжүүлж, тоног төхөөрөмж байршуулах, түрээслүүлэх үйлчилгээг нэвтрүүлэхээр ажиллаж байна.





## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

“Айтүүлс” ХК нь 2017 оны 11 дүгээр сард нийт хувьцааны 38.86%-ийг олон нийтэд нээлттэй болгосноор дараах хувьцаа эзэмшлийн бүтэцтэй болоод байна.



Айтүүлс ХК-ийн 2017 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 10-ны өдрийг хүртэл анхдагч зах зээлийн арилжааны захиалга авсан ба компанийн үнэт цаасыг худалдан авах захиалга нь нийлүүлэлтээсээ 3 дахин их буюу нийт 3.9 тэрбум төгрөгт хүрснээр, Монголын хөрөнгийн зах зээлд үнэт цаас гаргасан компаниуд дунд хамгийн их захиалга авсан компани болсон.

Айтүүлс ХК-ийн анхдагч зах зээлийн арилжаанд 1074 хөрөнгө оруулагчийн захиалгыг хүлээн авж, амжилттайгаар явагдсаныг Санхүүгийн зохицуулах хорооноос баталгаажуулж, хоёрдогч зах зээлийн арилжааг нийт 954 хувьцаа эзэмшигчтэйгээр эхлүүлэх зөвшөөрлийг олголоо.

Нийт 34,452,124 ширхэг энгийн хувьцааны 21,064,144 ширхэгийг “Ай Си Ти групп” ХХК эзэмшиж 13,387,980 ширхэг хувьцааг олон нийтэд нээлттэй арилжааллаа.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ**

**Дарга**



**Адилбиш  
БАТТАМИР**

Нэр дэвшүүлэх хорооны гишүүн

**Нарийн бичгийн дарга**



**Баянбат  
АРИУНЗУЛ**

**Хараат бус гишүүд:**



**Дамдинсүрэн  
ДАВАА**

Цалин урамшууллын  
хорооны гишүүн



**Зэсэм  
МЯГМАРСҮРЭН**

Аудитын хорооны  
дарга, цалин  
урамшууллын хорооны  
гишүүн



**Энхтуяа  
НАРАНМӨНХ**

Нэр дэвшүүлэх  
хорооны гишүүн



**Лхагва  
ТЭМҮҮЛЭЛ**

Нэр дэвшүүлэх  
хорооны дарга,  
аудитын хорооны  
гишүүн

**Ердийн гишүүд:**



**Идэрмөнх  
АЛТАНТУЛГА**



**Нанжид  
УЛААНХҮҮ**  
Аудитын хорооны  
гишүүн



**Гантулга  
ХАТАНБОЛД**  
Цалин урамшууллын  
хорооны дарга



**Баярмагнай  
ЭРДЭНЭЖАРГАЛ**

## ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

### ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



Монгол инженер, Монгол баг хамт олны чадамж бүтээгдэхүүн үйлчилгээнд итгэл дүүрэн байж, мэдээллийн технологийн салбарыг хурдасгах хөшүүрэг болсон хөрөнгө оруулагчид, харилцагч та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Ай Түүлс ХК-ийн хувьд өдрөөс өдөрт хувьсан өөрчлөгдөж буй мэдээллийн технологийн орчинд хэрэглэгчдийнхээ хэрэгцээ, шаардлагыг үйл ажиллагааныхаа цөм болгож, ёс суртахуунтайгаар зогсолтгүй хөгжиж, хөдөлмөрлөх, амжилтаараа ялгарах нь бидний амжилтын үндэс болдог хэмээн үздэг билээ.

Бид хөрөнгө оруулагчид болон, харилцагчдынхаа дуу хоолойг байнга сонсож, хамтдаа хөгжин дэвждэг. Ингэснээр бид хэрэглэгчдийнхээ хэрэгцээ шаардлагад бүрэн нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээ гаргаж, чанараа улам нэмэгдүүлж илүү найдвартай үйлчилгээг үзүүлж, салбарын хөгжлийг хурдасгахад хувь нэмрээ оруулсаар байна.

Бид мэдээллийн технологийн суурь, дэд бүтцийн үйлчилгээний туршлагадаа үндэслэн технологийн эрин үеийг дэлхий нийттэй зэрэгцэн хүргэхээр тэмүүлэн ажиллаж байна.

Орчин үеийн амьдралын хэв маяг цахим хэлбэрт шилжихийн хэрээр байгууллага төдийгүй хувь хүний мэдээллийн нууцлалын асуудал хурцаар хөндөгдөж байна. Айтүүлс ХК нь мэдээллийн аюулгүй байдалд онцгой анхаарал хандуулах бөгөөд Олон улсын чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001 болон Олон улсын мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO 27001 стандартаар баталгаажсан Монгол Улсад төдийгүй дэлхийд жишиг компани болохоор зорилт тавьж байна.

Бид эдгээр стандартуудыг өдөр тутмын бүхий л ажилдаа мөрдлөгөө болгосоноор хэрэглэгчдийнхээ мэдээллийн нууцлалыг чандлан хадгалахын сацуу чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээгээр тогтмол хангах учиртай.

Та бүхний хамтын ажиллагаа, дэмжлэгт чин сэтгэлээсээ талархал дэвшүүлж, Та бүхний хүлээлтийг үргэлж давуулан биелүүлэхээ амлаж байна.

Ай түүлс ХК-нд итгэл хүлээлгэн хөрөнгө оруулсан та бүхэнд талархал илэрхийлье.

Баярсайханы Тамир  
Гүйцэтгэх захирал

## 2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2017 он бол Айтүүлс ХК-ийн хувьд олон томоохон үйл явдлууд өрнөсөн чухал жил болж өнгөрлөө. Тухайлбал:

- Борлуулалтын орлого болон ашгийн хэмжээ хамгийн их өсөлттэй,
- Уламжлалт дата төвийн харилцагч, үзүүлж буй үйлчилгээний тоо түүхэн өндөр түвшинд хүрсэн,
- Олон нийтэд хувьцаагаа санал болгосон (IPO),
- Модуляр дата төвийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн
- Блокчэйн дата төвийн үйл ажиллагааг эхлүүлсэн
- Экспортын борлуулалт нэмэгдсэн

Дээрх үйл явдлуудын талаар товчлон хүргэвэл:

*Борлуулалтын орлого болон ашгийн хэмжээ өмнөх онуудтай харьцуулбал хамгийн их өсөлттэй байлаа.*

Айтүүлс ХК-ийн санхүүгийн зарим үзүүлэлтийг 2016 онтой харьцуулбал:

- |                                      |                                 |
|--------------------------------------|---------------------------------|
| - Борлуулалтын орлого                | 181%-иар буюу 2.81 дахин        |
| - Цэвэр ашиг                         | 282%-иар буюу 3.82 дахин        |
| - Үйл ажиллагааны зардал             | 17%-иар                         |
| - Дотоодыг зах зээл дээрх борлуулалт | 196%-иар буюу 2.96 дахин        |
| - Экспортын борлуулалт               | 36%-иар                         |
| - Төсөвт төлсөн татвар               | 24%-иар                         |
| - Компанийн зах зээлийн үнэлгээ      | 52%-иар                         |
| - Ажилтны тоо                        | 42%-иар тус тус нэмэгдсэн байна |

2017 онд нийт борлуулалтын орлого 1.33 тэрбум төгрөгт хүрч 181%-аар өссөн байна. Ийнхүү өсөхөд датацентрийн буюу үндсэн үйл ажиллагааны орлого 559.7 сая хүрч 17.8%-аар өссөний зэрэгцээ компанийн шинэ бүтээгдэхүүн болох клауд майнинг, крипто фармын үйлчилгээнээс олсон орлого 773.9 сая төгрөг болж нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

*Хүснэгт 2. Компанийн санхүүгийн байдал. 2015-2018 он*

Үзүүлэлт	2015	2016	2017
Борлуулалтын орлого	312 663 010	474 905 307	1 333 663 972
Борлуулалтын орлого. Уламжлалт дата төв	312 663 010	474 905 307	559 691 848
Борлуулалтын орлого. Блокчэйн дата төв			773 972 123
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	84 679 757	95 126 634	851 449 899
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	84 679 757	95 126 634	116 176 383

Уламжлалт дата төв			
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг Блокчэйн дата төв			735 273 517
Нийт ашиг/алдагдал	227 983 253	379 778 673	482 214 072
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	4 742 366	14 178 670	19 300 263
Үндсэн үйл ажиллагааны зардал	220 836 286	367 961 232	431 567 892
ТТӨА/алдагдал	11 889 333	20 613 937	69 946 443
Татварын зардал	781 685	2 285 306	6 994 644
Цэвэр ашиг/алдагдал	11 107 648	18 328 631	62 951 799
Ашгийн маржин	3,6%	3,9%	4,7%

Ийнхүү борлуулалтын орлого нэмэгдсэн, зардлын өсөлт борлуулалтын орлогын өсөлтөөс бага байсан зэргээс шалтгаалан ашигт ажиллагаа 282%-аар нэмэгдэж, 62.9 сая төгрөгт хүрсэн байна. Ингэснээр ашгийн маржин өмнөх оноос 22%-аар өсч 4.7%-д хүрсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны ББӨ нь борлуулсан бүтээгдэхүүний хэмжээ нэмэгдсэнтэй холбоотойгоор 95.1 сай төгрөгөөс 116.2 сай төгрөг болж, 22.1%-аар нэмэгдсэн.

ББӨ 795%-аар өссөн нь байгаа нь клауд майнинг үйлчилгээ эхлүүлсэнтэй холбоотой бөгөөд тус бүтээгдэхүүний орлогыг компани хүлээж аваад 5%-ийг нь бүтээгдэхүүний үйлчилгээний төлбөрт авч, үлдэгдэл төлбөрийг тоног төхөөрөмж эзэмшигч Клауд майнинг ХХК-д шилжүүлдэг онцлогтой бүтээгдэхүүн тул ББӨ ийнхүү нэмэгдсэн байна.

*Уламжлалт дата төвийн харилцагч, үзүүлж буй үйлчилгээний тоон үзүүлэлтүүд өмнөх онуудтай харьцуулбал хамгийн өндөр түвшинд хүрсэн.*




Идэвхтэй хэрэглэгчийн тоо

**5200+**



Идэвхтэй үйлчилгээ

**10000+**



*Зураг 5. 2015-с 2017 онд шинээр борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ*

---

*Монголын хөрөнгийн биржийн түүхэн дэх хамгийн олон дээд амжилтыг тогтоосон маш амжилттай IPO болсон.*

---

“Айтүүлс” ХК-ийн анхдагч зах зээлийн захиалгад 1,072 хувь хүн, аж ахуйн нэгжүүд оролцож, нийтдээ 39,786,996 ширхэг үнэт цаасны худалдан авах захиалга өгснөөр захиалга нийлүүлэлтээсээ 3 дахин их буюу нийт 3.9 тэрбум төгрөгт хүрсэн. Мөн хувьцааны ханш 270%-ийн өсөлтийг үзүүлсэн зэрэг үзүүлэлтүүдээр Монголын хөрөнгийн зах зээлд үнэт цаас гаргасан компаниуд дунд хамгийн амжилттай IPO болсон юм..

---

*Модуляр дата төвийн паркийн бүтээн байгуулалтын ажлыг Дархан-Уул аймагт эхлүүлсэн.*

---

Барилга угсралтын “Стандарт проперти” ХХК-тай Модуляр дата төвийн барилга, түүний цэвэр бохир ус, дулаан болон цахилгааны дэд бүтцийн угсралт, гадна хашаа болон тохижилтын ажлыг гүйцэтгүүлэхээр 2017 оны 8 сарын 21-ны өдрийн №08/12 тоот ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан.

Гэрээний дагуу тус компани нь 2017 оны 9 сараас эхлэн барилгын туслан гүйцэтгэгчтэй хамтран барилга угсралтын ажлыг эхлүүлэн модуляр дата төвийн барилгын 40% гүйцэтгэлтэйгээр ажиллаж байна.



Зураг 6. Модуляр дата төвийн паркийн барилгын ажлын үеэр


Төслийн хүрээнд 3-р зэрэглэлийн сертификат бүхий нэг контейнер дата төвийг худалдан авах бөгөөд худалдан авах захиалга хийж урьдчилгаа төлбөрийг төлөгдсөн байдалтай байна.

*Орчин үеийн мэдээллийн технологийн тэсрэлт болж буй Блокчэйн технологийн тоног төхөөрөмжүүдийг ажиллуулах зориулсан блокчэйн дата төвийн үйл ажиллагааг эхлүүлсэн.*

Крипто валют олборлох зориулалт бүхий тоног төхөөрөмжийн хүчин чадлыг түрээслүүлэх клауд майнинг үйлчилгээг “Клауд майнинг” ХХК-тай хамтран эхлүүлж 2017 онд эхлүүлж 2 удаагийн захиалгаар 774 сая төгрөгийн борлуулалтын орлого олоод байна.

*Экспортын борлуулалт нэмэгдсэн.*

Япон, Орос, Хятад, Англи, Австрали, Израль, Тайланд, Украин, АНУ, Өмнөд солонгос зэрэг 12 орны хэрэглэгчдэд жилд 60 сая гаруй төгрөгийн экспортын бүтээгдэхүүнийг борлуулж байна.



Зураг 7. Экспортын орлогын харьцуулсан график. (Сая төгрөгөөр)

## Аудитын дүгнэлт



### СҮЛД-АУДИТ ХХК

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, АУДИТ, СУРГАЛТ

САНХҮҮГИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ, ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ

2018 ОН 7 САР 22 ӨДӨР

№ 15191

УЛААНБААТАР ХОТ

#### “АЙТҮҮЛС” ХК-ИЙН УДИРДЛАГАД

#### Санхүүгийн Тайлангийн Аудитын Талаарх Тайлан

#### Зөрчилгүй Дүгнэлт

Бид 2017 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээр орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн “Айтүүлс” ХК-ийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар “Айтүүлс” ХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал, тухайн жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв толилуулж байна.

#### Дүгнэлтийн Үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлага энэ тайлангийнхаа Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу Байгууллагаас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлага бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

#### Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Эгтээдүүдийн Санхүүгийн Тайланд хүлээх Үүрэг Хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Байгууллагын үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах байгууллагын чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Байгууллагын санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

#### Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийлээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үл үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэгсэлчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай материаллагт тооцогддог.

ХҮНДЭТГЭСЭН  
Сүлд-Аудит ХХК  
Ерөнхий Захирал, МНБ  
Ч.Гүндсүр

Хаяг: Улаанбаатар хот  
Сүхбаатар дүүрэг Бөгө тойруу,  
8-р хороо 11-р хороондот GB-center 602 тоот

E-mail: info@suld-audit.mn  
Gundabayar@suld-audit.mn  
Web: www.suld-audit.mn

Утас: (976) 70118016  
(976) 99114056



**Аудитын дүгнэлт**

АЙЛТҮЭС ХК-ИЙН 2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ			
Д/А	А.Үлдэгдлийн тэнцэл	Үлдэгдэл	
		01-р сарын 01	12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	16,189,047.46	412,006,757.57
1.1.2	Дансны авлага	86,902,942.73	40,741,491.57
1.1.3	Татвар НДШ-н авлага	3,343,960.05	
1.1.4	Бусад авлага		116,583,296.57
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Баривч мөнгө	120,372,340.71	61,762,184.46
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	127,806,703.45	195,474,120.68
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулж зорилгоор зэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (Борлуулах булаг хөрөнгө)		
<b>1.1.10</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>334,604,864.40</b>	<b>826,569,850.85</b>
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Түндэсн Хэрэгч	1,157,046,027.79	2,203,953,316.26
1.2.2	Биег бус хөрөнгө	56,290,330.91	56,577,230.91
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	70,446,145.00	70,446,145.00
1.2.5	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.6	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.7	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.8	Дууссагүй барилга		
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,283,782,603.70	2,330,676,892.17
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,618,287,488.10</b>	<b>3,157,246,643.02</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	44,844,508.99	29,314,467.43
2.1.1.2	Татварын өр	27,240,393.04	49,191,617.01
2.1.1.3	Цэцгийн өглөг	3,839,317.89	
2.1.1.4	НДШ-ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл	45,713.50	39,459.56
2.1.1.6	Хүүгийн өглөг		
2.1.1.7	Нэгдэл ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	115,821,449.57	242,620,465.29
2.1.1.9	Бусад Богино Хугацаат өр төлбөр/	5,956,800.00	13,831,400.00
<b>2.1.1.10</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>197,788,192.99</b>	<b>334,997,429.29</b>
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.2	Урт хугацаат өр төлбөрийн дүн	0.00	0.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	197,788,192.99	334,997,429.29
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>	<b>956,756,223.28</b>	<b>2,244,856,223.28</b>
2.3.1	Өмч:		
2.3.2	- хувийн	905,756,223.28	905,756,223.28
2.3.3	- хувьцаат		1,338,796,000.00
2.3.4	Халаасны урьдны		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	460,721,652.19	460,721,652.19
2.3.7	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.8	Хуримтлагдсан ашиг /алдагдал/	54,019,439.64	116,971,238.26
<b>2.3.9</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>1,420,499,316.11</b>	<b>2,822,249,113.73</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,618,287,488.10</b>	<b>3,157,246,643.02</b>
<b>Б.ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН</b>			
1	Борлуулалтын орлого (цэвэр)		1,333,963,071.57
2	Борлуулалтын өртөг		851,449,856.49
<b>3</b>	<b>Нийт ашиг (алдагдал)</b>		<b>482,214,072.08</b>
4	Түрээсийн орлого		9,090,909.09
5	Бусад орлого		1,147,298.06
6	Борлуулалт маркетингийн зардал		
7	Ерөнхий ба удирдлагын зардал		431,567,862.06
8	Санхүүгийн зардал		
9	Бусад зардал		
10	Гадаад валютын хөндийн зөрүүний олгогч		9,062,056.75
11	Бусад ашиг (алдагдал)		
12	Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/		69,946,442.92
13	Орлогын татварын зардал		6,994,644.29
14	Татварын дараах ашиг /алдагдал		62,951,798.62
<b>В.ЭЗДИЙН ӨМЧИЙН ТАЙЛАН</b>			
1	Эздийн өмчийн эхний үлдэгдэл		1,420,499,316.11
2	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/		62,951,798.62
3	Өмчид гарсан өөрчлөлт		1,338,796,000.00
4	Нягтлан бодж бургалийн борлогын өөрчлөлтийн нөлөө алдааны залруулга		
5	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт бууралт		
6	Нэгдэл ашиг		
7	Эздийн өмчийн эцсийн үлдэгдэл		2,822,249,113.73
<b>Г.МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН</b>			
1.1	Мөнгөн орлогын дүн		1,467,030,366.77
1.2	Мөнгөн зарлагын дүн		1,345,672,628.74
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		121,357,740.63
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн		1,147,298.06
2.2	Мөнгөн зарлагын дүн		1,046,807,286.47
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн		(1,046,659,980.41)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн		1,338,796,000.00
3.2	Мөнгөн зарлагын дүн		27,738,096.26
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн		1,311,057,904.74
4	Зарлагын хөндийн зөрүү		9,062,056.75
5	Бусад хөрөнгө оруулалтын зардал		395,819,716.11
6	Мөнгөн зарлагын бусад зардал		16,189,047.46
7	Мөнгөн зарлагын зардал/алдагдал		412,006,757.57

Санхүүгийн тайлан ба тооцоогүйсний аудитор  
 Төрийн үйлчилгээний байр  
 Co., Ltd

## Ногдол ашгийн талаарх мэдээлэл



### АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 02 сарын 08 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

#### Ногдол ашиг хуваарилахгүй тухай

“Айтүүлс” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Айтүүлс” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу компанийн хэрэгжүүлж буй төсөл бүрэн дуусаагүй байгаагийн зэрэгцээ компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор 2017 оны ашгаас ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.
2. Шийдвэртэй холбоотой мэдээллийг хууль, тогтоомжид заасан хугацаанд холбогдох байгууллага болон хувьцаа эзэмшигчдэд мэдээлэхийг Гүйцэтгэх захирал /И.Алтантулга/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



А.БАТТАМИР